



Г ГУРВАНЗАГАЛ СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНЫ
ДАРГА З.ГАНБАТ ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.07.19 № 507
танай 2024.07.18 -ны № 14 -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Гурванзагал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Гурванзагал сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

011021399

Дүгнэлт

Гурванзагал сумын Монгол ардын намын Гурванзагал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Гурванзагал сумын Монгол ардын намын мөрийн хөтөлбөр дөрвөн хуудас хавсаргав.

Хувийг: “Гурванзагал сумын Монгол ардын намын хороо”-нд

Хувийг: Дорнод аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 4 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

**ГУРВАНЗАГАЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС
2024 ОНЫ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

УРИА: "Сумандаа сайхан амьдаръя"

1. Гурванзагал суманд 250 хүүхдийн багтаамжтай сургуулийн байр шинээр барих
2. Сумын төвийг нэгдсэн халаалтын системд холбох
3. Гурванзагал сумын ЗДТГ-ын барилга шинээр барих
4. Сумын төвд 10км хатуу хучилттай зам засварлах
5. Сумын төвийн эрчим хүчний дэд станцыг өргөтгөх/35кв/
6. Сумын ЭМТ-ийн барилгыг өргөтгөх
7. Гудамжны гэрэлтүүлэг нэмэгдүүлэх
8. Төвлөрсөн хогын цэгийг дарж булах, хог хаягдал устгах, ангилах цех байгуулах
9. Сумын төвд нийтийн ЭКО бие засах газартай болох
10. Залуу гэр бүлүүдэд зориулсан нийтийн орон сууц барих



НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1 ЭРҮҮЛ ИРГЭН

1.1.1 Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” зорилтын хүрээнд “Элэг бүтэн Монгол”, “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт идэвхжүүлж хүн амыг эрүүлжүүлэхэд онцгой анхаарч ажиллана.

1.1.2 . Сумын эмнэлгийг халуун, хүйтэн ус, ариун цэврийн байгууламжтай болгоно.

1.1.3 “Эрүүл идэвхтэй Гурванзагалчууд” сумын дэд хөтөлбөр боловсруулж, эрүүл мэндийн

анхан шатны тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, архи, тамхинаас гарах зөвлөгөө өгөх, сургалтад хамруулах арга хэмжээг эрчимжүүлж иргэдийг идэвхжүүлнэ.

1.1.4 Суманд тогтвор суурьшилтай ажиллах эмч, сувилагч нарын нийгмийн баталгааг сайжруулж, сумын ЭМТ-ийг мэргэжлийн залуу боловсон хүчингээр хангахад анхаарна.

1.1.5 Хүнсний аюулгүй байдлын тухай хуулийн хүрээнд хүнсний худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн худалдан борлуулж байгаа бараа бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулна.

1.2 ОРЛОГО БА ОРОН СУУЦТАЙ ӨРХ

1.2.1. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг дэмжих зорилгоор орон сууцтай болоход бодлогоор дэмжинэ.

1.2.2. Зорилтот бүлгийн иргэдийг жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх, ажлын байртай болоход бүх талын дэмжлэг үзүүлнэ.

1.2.3. ОНӨҮГ-ын үйл ажиллагааг ивэвхжүүлж, ОНХС-ийн хөрөнгөөр баригдсан өмч хөрөнгүүдийн ашиглалт хяналтыг сайжруулж, иргэдээ хөдөлмөрөөрөө хоршиж ажлын байр бий болгоход байр орон сууцны боломжоор хангаж өгнө.

1.3 ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ

1.3.1. ЕБС, цэцэрлэгийн багш мэргэжилтнүүдийн ажиллах нөхцөлийг сайжруулахад анхаарч, хариуцлагыг дээшлүүлэх, сургалтын чанарыг нэмэгдүүлэх талаар гаргасан шинэлэг санал санаачлагыг дэмжих урамшууллын арга хэлбэрүүдийг хэрэгжүүлнэ.

1.3.2. Багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоодын сургалт, үйл ажиллагаанд хамруулж, “Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.3.3. Боловсролын салбарыг улс төрөөс ангид байлгаж, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг мэдлэг чадвар, ажлын гүйцэтгэл, туршлага, харилцааны ёс зүйд нь үндэслэн сонгон шалгаруулж томилуулахад анхаарч ажиллана.

1.3.4 Хүүхдийг ханиад, томуу, халдварт өвчнөөс сэргийлэх зорилгоор сургууль цэцэрлэгийг хариуцсан эмчтэй болгож, хүүхдүүдэд эрүүл мэндийн боловсрол олгоход анхаарна.

1.3.5. ЕБС-ийн үдийн цай хөтөлбөрийн чанар хүртээмж, цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоол цайнд тавих хяналтыг сайжруулж, хүүхдэд шим тэжээл, амин дэмээр баялаг хоолоор үйлчилнэ.

1.3.6. Сумын залуучуудыг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамруулах, улс аймгийн чанартай уралдаан тэмцээнд оролцоход бүх талын дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

1.3.7. Хичээлээс гадуурх сургалтын хөтөлбөр бовсруулж хэрэгжүүлэх, хүүхэд, залуучуудын сонирхол, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд анхаарч "Авьяаслаг Гурванзагалчууд", "Эрүүл идэвхтэй Гурванзагалчууд" зэрэг сумын дэд хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж, хүүхэд, залуучуудын идэвх оролцоог нэмэгдүүлнэ.

1.3.8. Улс, аймгийн түвшинд зохион байгуулагдаж буй олимпиад, уралдаан, тэмцээнд оролцож, амжилт үзүүлсэн суралцагч, багш, сурагчдын, багийг дэмжиж урамшуулна.

-2025 онд сумын ЕБС-ийн 90 жилийн ой болохтой холбогдуулан сургуулийн хичээлийн байрны дээвэр шинэчлэх, дотуур байрны халаалтын зуухыг шинэчилж халаах хүчин чадлыг нэмэгдүүлэх,

-Цэцэрлэгийн байранд өргөтгөл хийж суралцагчдын сурч боловсрох орчин нөхцөлийг сайжруулна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Малчдын орлогыг нэмэгдүүлэхэд анхаарч, малчдын хоршоог хөгжүүлэх, тэднийг өрхийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

Малчид иргэдэд төрийн үйлчилгээг чанартай түргэн шуурхай хүргэхэд анхаарч, бэлчээрийг зүй зохистой ашиглах, өрхийн хадлан бэлтгэх, малын тэжээл тариалж нөөцлөхөд малчидтайгаа нягт уялдаа холбоотой ажиллаж, зудын эрсдэлээс хамгаалах менежмент боловсруулна.

Иргэдийг хямд өртөгтэй орон сууцаар хангах нөхцөлийг бүрдүүлж сумандаа тав тухтай амьдрах боломжоор хангана.

2.1 ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ

2.1.1. Малын тоо толгойн албан татварыг мал сүргийг хамгаалах, эрүүлжүүлэх арга хэмжээнд бүрэн зарцуулна. Үүнд:

-Гүн өрмийн худгыг цооногууд гаргаж бэлчээр усжуулах

-Мал ариутгалын машин авах

-Гал түймрийн аюулаас хамгаалах багаж хэрэгсэл авч малчдад гэрээгээр эзэмшүүлэх

2.1.2. ОНХС-ийн хөрөнгийг иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулахд зарцуулна.

- Хүлэмж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх замаар төмс, хүнсний ногооны өрхийн хэрэгцээг жилийн турш тогтвортой хангаж, өрх бүрийг хүнсний ногоо тариалах хөдөлгөөн өрнүүлнэ.

- Малын тэжээлийн үйлдвэрлэх, тариалах ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлж, өвс тэжээлийн аюулгүй нөөцийг нэмэгдүүлнэ.

-ОНӨҮГ-ыг хариуцах эзэнтэй болгож, суманд баригдаад ашиглалтгүй байгаа ахмад, залуучуудын байр, халуун усны газрыг сэргээн засварлаж иргэдэд гэрээгээр эзэмшүүлэн ажлын байр бий болгоход санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

- Хогын цэгийг цэгцэлж, хог хаягдал дахин боловсруулах, ангилах эко цех байгуулна.

-Суманд баригдсан 8 айлын орон сууц хөтөлбөрийг дахин хэрэгжүүлж, төвийн нэгдсэн халаалтанд холбох эх үүсвэрийг бий болгоно.

-Сумын төвийн замыг сайжруулах-10 км хатуу хучилттай зам засварлана.

-Сумын төвийн ундны усыг цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулна.

-Шинээр дэд станц байгуулж, эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлнэ. **35кв**

-Гудамжны гэрэлтүүлэг нэмэгдүүлнэ. –Лед гэрэлтүүлэг-20 ширхэг, цамхагт гэрэлтүүлэг 4 ширхэг

-Сургуулийн дээврийг шинэчлэх

ГУРАВ. 1 ШУДАРГА,ХАРИУЦЛАГАТАЙ ЗАСАГЛАЛ

- ✓ Монгол Ардын Нам цаашид хуулийн хэрэгжилтийг орон нутагт бүрэн хангаж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй, иргэдийн оролцоотой хүргэхэд голлон анхаарч, “Цахим Монгол” хөтөлбөрийн хүрээнд төрийн үйлчилгээг иргэдэд сурталчлан ойлгуулах ажлыг идэвхжүүлж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг сайжруулна.
- ✓ Орон нутагт төрийн байгууллагууд тогтвортой, төрийн алба мэргэшсэн байж төрийн албан хаагчид хариуцлагатай, үр дүнтэй ажилладаг болсноор орон нутгын хөгжлийн бодлого иргэдэд ойлгомжтой болж иргэдийн төрд итгэх итгэл нэмэгдэнэ.
- ✓ Төрийн албыг мэргэшсэн тогтвортой байх зарчмыг баримталж,төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг нэмэгдүүлэхэд анхаарч төрийн албан хаагчдыг мэдлэг чадвараа дээшлүүлэх, тэдний нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлж, жишиг сумдын төрийн албан хаагчдаас туршлага судлах, сэлгэн ажиллуулах зэргээр идэвх санаачлагыг нэмэгдүүлснээр ажлын бүтээмж, үр дүнг сайжруулна.

Ийнхүү төрийн албан хаагчид тогтвортой,мэргэшсэн чадварлаг байж, төрийн үйлчилгээ түргэн шуурхай, үр дүнтэй ажилладаг болсноор сум орон нутгын хөгжлийн бодлогыг алсын хараатай, судалгаа шинжилгээнд үндэслэн боловсруулж хэрэгжүүлэх,төрийн албан хаагчид улс төрийн болон цаг хугацааны шахалтад оролгүй ажлаа чанартай хийх нөхцөл бүрдэж, сумын иргэд орон нутагтаа амар тайван аятай тухтай ажиллаж амьдрах нөхцөл бүрдэн сумын өрсөлдэх чадвар нэмэгдэнэ.